

ЯПОНЫ УРАН ЗОХИОЛЫГ МОНГОЛ ХЭЛНЭЭ ОРЧУУЛСАН ТОЙМ /2007-2016/

С.Долгор¹³⁸, Ц.Онон¹³⁹

1. Оршил

Түүхийн олон зуун жилийн туршид монголчууд бид уйгар, төвд, санскрит, манж хэлнээс шинжлэх ухааны ном зохиол орчуулж ирсэн уламжлалтай бөгөөд өөр хэл соёлт орны утга зохиолын шилдэг сайн бүтээлүүд бусад орны утга зохиолын санд нэвтрэн орж зохих хэмжээгээр утга зохиолынх нь салшгүй хэсэг болдог. Энэхүү нэвтрэх зам нь орчуулга байдаг билээ. “Өөр ард түмний зохиол бүтээлийг өөрийн хэлэнд орчуулан гаргах нь бүтээлч ажиллагаа бөгөөд орчуулагчид нь зохиолчдын нэгэн адил утга зохиолын зүтгэлтэн нарын нэг болно” гэж эрдэмтэн, хэл шинжээч Н.И.Конрад “Өрнө ба Дорно” бүтээлдээ өгүүлжээ¹⁴⁰.

Олон зуун жилийн арвин их өв сантай, дэлхий дахинаа бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн утга зохиолтой улс бол Япон бөгөөд энэ орны утга зохиолд чөлөөт сэтгэлгээ, гүн ухаан гэх мэт дэлхийн утга зохиолын бүхий л өнгө аяс, урсгал чиглэл цөм бий. Бид энэхүү өгүүлэлдээ японы уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан байдал, онцлогийг товч өгүүлэн, сүүлийн арван жилд орчуулагдсан зохиол бүтээлийн бүртгэлийг хүснэгтлэн орууллаа.

2. Японы уран зохиолыг орчуулсан байдал

2.1 Уран зохиолын орчуулга

Уран зохиолын орчуулга нь бусад төрлийн ном зохиолын орчуулгаас ялгаатай, ур чадвар, уран сэтгэмж, өвөрмөц нарийн мэдрэмж шаарддаг бөгөөд зохиолчийн урлан бүтээсэн дүр, үйл явдлыг дахин амилуулах онцгой шаардлагатай тул зөвхөн хэл шинжлэл бус уран зохиол, орчуулгын онолын үүднээс судлах ёстойг эрдэмтэн Б.Бямбаа онцолсон байна¹⁴¹.

Утга зохиол шүүмжлэгч Р.Гүрбазар “Орчуулгын онол дадлагын үндэс” номондоо бүрэн биш тооцоогоор 1921-1984 оны хооронд монголын уншигчид дэлхийн 177 орны 12500 орчим зохиол бүтээлтэй орчуулгаар дамжин танилцсан хэмээн дурьджээ.

¹³⁸ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхимийн багш, доктор профессор


¹³⁹ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхимийн багш, доктор

¹⁴⁰ “Японы уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан тойм”-Японы утга зохиолын симпозиум илтгэлийн эмхэтгэл, Уб 2005, 25-32

¹⁴¹ “Монголын орчин үеийн уран зохиолын орчуулгын нэр томъёоны судлал”, Уб 2006

2.2 Японы уран зохиолыг орчуулсан тойм

Монгол, Япон хоёр орны утга зохиолын салбарын харилцаа 1950 оноос өрнөж эхэлсэн ба дэлхийн утга зохиолын санд онцгой байр суурь эзлэх эртний их өв соёлт японы утга зохиолтой монголчууд одоогоос жар гаруй жилийн өмнөөс танилцаж эхэлсэн байна.



Энэ хугацаанд нийт 160 гаруй зохиолчийн 450 орчим бүтээл хэвлэгдэн гарсан байна¹⁴².

1. Орчуулсан зохиолын төрөл зүйл, орчуулсан хэл

Японы уран зохиолын орчуулгыг дараах байдлаар ангилж болно.

1. 1953 оноос 1980-аад оны дунд үе хүртэлх үеийн орчуулга (яруу найраг голлосон)
2. 1980 оны дунд үеэс өнөөг хүртэлх үеийн орчуулга (үргэлжилсэн үгийн зохиол голлосон)

2.2.1 1953-1980 оны үеийн орчуулга



¹⁴² Энэхүү тоймыг гаргахдаа 1953-1984 оны хооронд хэвлэгдсэн ном зохиолын бүртгэлийг судлаач Ш.Базар, Г.Пүрэвдорж, С.Долгор, Д.Мандах нарын бүртгэл, бүтээлээс, 1985-2015 оны хооронд хэвлэгдсэн ном зохиолын бүртгэлийг сонин, хэвлэл, Улсын төв номын сан, МУИС-ийн Монгол-Японы Төвийн номын сангаас бүртгэн гаргалаа.

2. 1953 оноос 1980 оны үеийн орчуулгын төрөл

1955 он хүртэл Японы 26 зохиолчийн 33 бүтээл хэвлэгдсэн тоо баримт байна. Хүүхдийн зохиолч Ж.Дашдондог 1999 онд бичсэн “Миний уншсан япон номнууд” өгүүлэлдээ “...Монголын бяцхан уншигчид чухам хэдийнээс Япон хүүхдийн зохиолтой танилцсан юм бол. Номын сангаас хайгаад тавь жараад онд бага залуудаа уншиж байснаас урагших үеийнхийг олсонгүй. Түүнээс цааших үеийнх үл тааралдахыг бодоход дайны хар сүүдэрт боссон үзэл суртлын зузаан ханыг ямар ч сайн зохиол нэвтлэн орж чадаагүй биз” хэмээн өгүүлээд манай нэрт яруу найрагч Ч.Чимэдийн орчуулга “Япон хүний үг” (1955) гэдэг яруу найргийн ном уншсанаа болон энэ номонд хоёр сурагч охин шүлэг бичсэнийг олж мэдээд өөрөө шүлэг бичих гэж оролдож байснаа дурсан бичсэн байдаг¹⁴³. Зохиолч Ж.Дашдондог японы хүүхдийн уран зохиолыг монголын хүүхэд багачуудад хүргэх талаар дорвитой ажил хийж байгаа бөгөөд японы яруу найрагчдын бүтээлийг орос хэлнээс орчуулан “Улаан шувуухай” нэртэйгээр гаргажээ.

Хүний тэгш эрхийг хүндэтгэх, энэрэн хайрлах, дэлхий нийтийн энх амгалан байдал, эзэрхэг дайныг эсэргүүцэх, хүн төрөлхтний ирээдүй болсон үр хүүхдээ хайрлах сэтгэлийг агуулга болгосон дэлхийн олон орны уран зохиолоос орчуулан “Дэлхийн зохиолчид энх тайвны төлөө эмхэтгэл” 1953 онд гарч, энэ эмхэтгэлд Японы зохиолч Казү Сэндагийн “Хойд зүгийн хөлөг онгоц” шүлгийг нэрт яруу найрагч Ч.Лхамсүрэн, Сэй.С.О (нууц нэр) “Манай дуу”-г Ц.Шагдар, Агаки Шигэо “Цагаан будааны тариалан”-г Т.Жамбал нар монгол хэлнээ орчуулж гаргасан нь японы яруу найргийн орчуулгын анхных нь гэж үзэж болохоор байна¹⁴⁴. Энэ шүлгүүд хожим нь 1958 онд “Ази, Африкийн орны яруу найраг”-г дахин хэвлэгдэн гарсан байна. Энэ үед орчуулагдан гарсан гол зохиол, бүтээлүүдийг дурдвал,

- 1955 он “Япон хүний үг” яруу найргийн бие даасан эмхэтгэл
- 1955 он “Улаан тугийн дэргэд” үргэлжилсэн үгийн зохиолын анхны бие даасан эмхэтгэл
- 1960 он С.Нацүмэ “Жаалхүү” тууж
- 1962 он “Япон ардын зүйр цэцэн үгс” /англи хэлнээс/
- 1963 он Т.Кобаяши “Шарх” өгүүллэг /эх хэлнээс нь анхлан/
- 1974 он “Японы яруу найраг” 85 зохиолчийн бүтээл орсон японы яруу найргийн томоохон бүтээл орно.

1957 онд манай ардын уран зохиолч, эрдэмтэн Ц.Дамдинсүрэн Япон улсад атомын бөмбөгийг эсэргүүцсэн олон улсын 3-р бага хуралд оролцож ирээд “Японд очсон замын тэмдэглэл”-ээ хэвлүүлжээ.

¹⁴³ “Миний уншсан япон номнууд”, Ниппон Ньюс 1999.6.7


¹⁴⁴ С.Долгор “Японы уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан тойм” - Японы утга зохиолын симпозиум илтгэлийн эмхэтгэл, Уб 2005, 25-32

Энэ үед орчуулсан нийт зохиолын 97% нь орос хэлнээс дам орчуулсан зохиол байгаа бөгөөд тэдгээрийг Б.Явуухулан, Ч.Чимэд, Ж.Лхагва, М.Цэдэндорж, О.Цэндсүрэн, Х.Мэргэн нарын тухайн үеийн нэрт зохиолч, орчуулагчид орчуулсан бол Д.Батаа, Д.Алмаас, Т.Чойжилжав нар эх хэлнээс нь орчуулж байжээ.

2.2.2 1980 оноос өнөөг хүртэлх үеийн орчуулга

Өмнө өгүүлсэнчлэн энэ үеийн орчуулгад үргэлжилсэн үгийн зохиол голлосон байдаг бөгөөд дийлэнх зохиолыг эх хэлнээс нь орчуулсан байна. Үүнд дараах нийгэм, улс төрийн таатай байдал нөлөөлжээ.

- 1972 он Монгол, Япон хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтсон,
- 1975 он МУИС-ийн Хэл бичгийн факультетэд япон хэлийг сонгон судлах байдлаар зааж эхэлсэн,
- 1972 он Зохиолчдын хорооны дэргэд орчуулгын зөвлөл байгуулагдан “Орчуулах эрдэм” цуврал гарч эхэлсэн,
- 1977 он Япон улсад хэлний мэргэжил дээшлүүлэгч суралцах болсон,



3. 1980 оноос өнөөг хүртэлх үеийн орчуулгын төрөл, орчуулсан хэл

Энэ үед нийт 300 орчим зохиол бүтээл орчуулсан бөгөөд сүүлийн 10 жилд тууж, роман зэрэг томоохон хэмжээний зохиолын орчуулгын ажил чамгүй хийгдсэн байна (Хавсралтаас үзэх). Энэ үеийн эхэн хагасын орчуулгын гол зохиолыг дурдвал,

- 1985 онд хэвлэгдсэн “Японы зохиолчдын өгүүллэгүүд”
- Кавабата Ясүнари, Акүтагава Рюүносүкэ, Мишима Юкио, Мори Оогай нарын тууж, өгүүллэгийн түүвэр
- Шиба Рёотаро, Фүкүзава Юкичи, Морита Акио зэрэг зохиолчийн тэмдэглэл, эссэ, баримтат өгүүллүүд
- Күрота Хякүзо, Цүда Норико нарын жүжгийн болон хүүхдийн зохиол
- Хайкү шүлгийн орчуулга

байгаа бол сүүлийн хагаст орчуулагдсан дорвитой зохиол бүтээлд дараах зохиолуудыг дурдаж болно.

- Мүрасаки Шикибү “Гэнжийн туульс”
- Томоохон романууд
- Нацүмэ Соосэки “Санширо”, “Муур миний өчил”, “Сэтгэл”

Мүраками Харүки “Норвегийн ой”, “1Q84”

- Туужууд
- Мори Оогай, Хигүчи Ичиё, Ёшимото Банана

Энэ үеийн голлох орчуулагчид нь Ж.Оюунцэцэг, Б.Сэржав, С.Долгор, Д.Наранцэцэг, Д.Төмөрбаатар, О.Жаргалсайхан зэрэг МУИС-ийг төгссөн мэргэжилтнүүд байна. Мөн японы судлаач, зохиолчид жүжгийн болон хүүхдийн зохиолыг монголоор орчуулсан байна. Сүүлийн жилүүдэд Монголын Орчуулагчдын Эвлэлээс орчуулгын уралдааныг тогтмол зарлан, оюутан залуус англи, япон хэлнээс японы уран зохиол, тэр дундаа богино өгүүллэг ихээр орчуулах болсон байна.

3. Дүгнэлт, цаашид анхаарах зүйл

Японы уран зохиолын орчуулга нь монголын уран зохиолын орчуулгад хэдийн зохих байр сууриа эзэлж чадсан байна. Гэсэн хэдий ч эдгээр зохиолын орчуулгын онцлогийг орчуулга судлалын онол, арга зүйд тулгуурлан судласан судалгааны ажил тун цөөн байна. Улмаар цаашид Японы утга зохиолын орчуулгад дараах судалгааны ажлуудыг хийх хэрэгтэй гэж үзэж байна.

Үүнд:

- Орчуулгын үнэлгээний шалгуур боловсруулах (орчуулгын жанр тус бүрээр)
- Орчуулгын алдаанд шинжилгээ хийх, шүүмжийг хөгжүүлэх (галиглах аргыг жигдлэх, хэл найруулга, үг үсгийн алдаа г.м.) зэрэг болно.

Ном зүй

1. Базар.Ш, “БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиол, утга зохиол судлалын ном зүй 1970-1972”, Уб 1974
2. Базар.Ш, “БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиол, утга зохиол судлалын ном зүй 1973-1974”, Уб 1976
3. Базар.Ш, “БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиолын ном зүй 1977-1980”, Уб 1983
4. Базар.Ш, “БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиолын ном зүй 1981-1984”, Уб 1987
5. Гүрбазар.Р, “Орчуулгын онол дадлагын үндэс”, Уб 1966
6. Долгор.С, “Японы уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан тойм”-Японы утга зохиолын симпозиум илтгэлийн эмхэтгэл, Уб 2005, 25-32

7. Мандах.Д, “Японы уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан туршлага, зарим шинэлэг асуудал”, Уб 2010
8. Пүрэвдорж.Г, “1965-1969 онд орчуулагдсан гадаадын уран зохиолын бүртгэл”, Уб 1972
9. “Монголын орчин үеийн уран зохиолын орчуулгын нэр томъёоны судлал”, Уб 2006

Хавсралт. Монгол хэлнээ орчуулагдсан японы зохиол, бүтээлүүд /2007-2016/

Японы уран зохиолын 1953-1984 он хийгээд 1985-2007 оны хооронд орчуулагдан хэвлэгдсэн ном зохиолын бүртгэлийг судлаач С.Долгор, Д.Мандах нарын өгүүлэл, судалгааны бүтээлээс үзэж танилцах боломжтой тул доорх бүртгэлд 2007-2016 оны хооронд буюу сүүлийн арван жилд орчуулагдсан зохиолыг оруулав.

Д/д	Он	Орчуулагч	Зохиолч	Зохиолын нэр	Бичлэгийн төрөл	Эмхтгэлийн нэр
1	2008	Г.Аюурзана	Башё Мацүо	Сонгомол хайкү	шүлэг	Дэлхийн сонгомол яруу найраг
2			Ёсано Бүсан	Сонгомол хайкү	шүлэг	
3	2008	Ц.Онон	Оэ Кэнзабүр о	Хүн хонь	өгүүллэг	сонин
4	2009	Г.Ханхүү нар	Нацүмэ Сосэки	Сэтгэл	роман	
5	2009	Ц.Онон	Акүтагава Рюносүкэ	Тошишюн	өгүүллэг	Хамар
6				Хамар	өгүүллэг	
7				Төмсний зутан	өгүүллэг	
8				Кавабата Ясүнари	Ангийн даргын мөрдлөгө	
9	2010	Ц.Онон	Хигүчи Ичиё	Булингарт булан	тууж	Булингарт булан
10				Такэкүрабэ	тууж	
11				Хүүхэд	өгүүллэг	
12	2010		Мацүмот	Номун ханы	тэмдэглэ	

			о Сүүхэ	ээрэм талд	л	
13	2011	С.Оюунбилиг	Ёшимото Банана	Гал тогооны өрөө	тууж	
14	2011	Б.Жаргалсайх ан	Ёшикава Эйжи	Самүрайн замнал	роман	
15	2012	Д.Оюунтүшиг	Хосоки Казүко	Зургаан гарагийн зурхай	тууж	
16	2012	Т.Болдбаатар		Лянхуан гурамсан судар	судар бичиг	
17	2012	П.Наранбаяр	Мори Оогай	Зэрлэг галуу	тууж	
18	2012	Г.Аюурзана	Кавабата Ясүнари	Юмиүра	өгүүллэг	Дэлхийн сонгомол өгүүллэг
19				Шөнийн шившлэгт шоо	өгүүллэг	
20				Хаврын нэг сайхан өглөө 100% төгс бүсгүйтэй тааралдсан тухай	өгүүллэг	
21	2012	Б.Батаа	Акүтагава Рюносүкэ	Рашёомон хаалга	өгүүллэг	Намрын уулс
22				Ганцаардлын там	өгүүллэг	
23				Үнэнч сэтгэл	өгүүллэг	
24				Күраносүкэгийн нэг өдөр	өгүүллэг	
25				Уран бүтээлийн онгод	өгүүллэг	
26				Ёносүкэгийн яриа	өгүүллэг	

27				Аалзны шүлс	өгүүллэг	
28				Тамын тарчлал	өгүүллэг	
28				Хүйтэн талын тухай нэг зүйл	өгүүллэг	
30				Тошишюн	өгүүллэг	
31				Сүүдэр	өгүүллэг	
32				Намрын уулс	өгүүллэг	
33				Шугуйд	өгүүллэг	
34				Сүсано-но-Микото	өгүүллэг	
35				Сүсано-но-Микотогийн ахмад нас	өгүүллэг	
36				Хэрэн бэдэхийн бурханы яриа	өгүүллэг	
37				Эссэ	эссэ	
38	2014	Ц.Онон	Мори Оогай	Такасэбүнэ	өгүүллэг	Сонгодог өгүүллэгийн дээжис
39		Л.Адъяасүрэн	Акутагава Рюносүкэ	Өргөмөл хүү	өгүүллэг	
40		Б.Баясгалан	Накажима Ацүши	Их мэргэн	өгүүллэг	
41			Мишима Юкио	Манцуй	өгүүллэг	
42		С.Оюунбилиг	Абэ Кобо	Хүр хорхойн улаан үүр	өгүүллэг	
43			Акутагава Рюносүкэ	Бичтэй үзэлцсэн хавчийн түүх	өгүүллэг	
44			Койзүми Якүмо	Илбэнх	өгүүллэг	

45		Л.Хангал	Мүракам и Харүки	Түүний хот, түүний хонь	өгүүллэг			
46	2014	Д.Алтанцэцэг	Дазай Осамү	Гүй Мелос	өгүүллэг	Сэтгэлд хоногшсон өгүүллэгүү д		
47				Царцаа	өгүүллэг			
48			Акүтагава Рюносүкэ	Тэргэнцэр	өгүүллэг			
49				Бэрсүүт жүрж	өгүүллэг			
50				Хамар	өгүүллэг			
51			Мори Оогай	Сүүлчийн үг	өгүүллэг			
52				Саншёо Даюү	өгүүллэг			
53				Такасэ завь	өгүүллэг			
54			2014	Д.Алтанцэцэг	Миязава Кэнжи		Захиалга ихтэй зоогийн газар	өгүүллэг
55					Ямамото Юүзо		Шоколад	өгүүллэг
56					Ясүока Шёотаро		Циркийн морь	өгүүллэг
57					Аришима Такэо		Нэг багц усан үзэм	өгүүллэг
58					Изүми Кёока		Мэс заслын өрөө	өгүүллэг
59					Кикүчи Кан		Аав ирэв	өгүүллэг
60	Амиа егүүтгэгчийг аврах ажил	өгүүллэг						
61	2015	Л.Адъяасүрэн			Акүтагава Рюносүкэ	Тэргэнцэр	өгүүллэг	Бурхдын инээмсэглэ л
62			Бэрсүүт жүрж	өгүүллэг				
63			Ганцаардлын там	өгүүллэг				
64			Сонин түүх	өгүүллэг				

65				Охин	өгүүллэг	
66				Ач хариулах тухай	өгүүллэг	
67				Бурхдын инээмсэглэл	өгүүллэг	
68				Кичисүкэ	өгүүллэг	
69				Гэгээнтэн	өгүүллэг	
70				Санъэмоны хэрэг	өгүүллэг	
71				Кэса Морито хоёр	өгүүллэг	
72				Хоёр Комачи	өгүүллэг	
73				Момотаро	өгүүллэг	
74				Хавч сармагчин хоёрын халз тулаан	өгүүллэг	
75				Амаржих овоохой	өгүүллэг	
76				Бисэйн итгэл	өгүүллэг	
77				Дагина	өгүүллэг	
78				Харанхуйд асуух хийгээд хариулах	өгүүллэг	
79				Эртний анддаа илгээх захидал	өгүүллэг	
80	2015	Д. Дашмөнх	Акутагава Рюносүкэ	Тамын тарчлаан	өгүүллэг	Үхлийн тууриуд
81				Ширэнгэд	өгүүллэг	
82			Хар эх дагина	өгүүллэг		
83			Мишима Юкио	Хурган чихний цэцэг	өгүүллэг	

84				Эх оронч үзэл	өгүүллэг	
85			Абэ Кобо	Цэргийн ар	өгүүллэг	
86				Хүүхдийн өрөө	өгүүллэг	
87			Эдогава Рампо	Ихэр	өгүүллэг	
88				Улаан тасалгаа	өгүүллэг	
89			Кавабата Ясунари	Хулсны дуу тоорын цэцэг	өгүүллэг	
90	2015	Д.Алтанцэцэг	Мүшнянок ожи Санэацү	Андын сэтгэл	тууж	
91	2015		Мүракам и Харүки	Норвегийн ой	роман	
92	2014	О.Жаргал- сайхан	Мүракам и Харүки	1Q84 /3 боть/	роман	
93	2015	Ц.Цэнгэл	Мишима Юкио	Алтан сүм	роман	
94	2015	Л.Нарантуяа	Ототакэ Хиротада	Амьдрал ямар сайхан гээч	дурсамж	
95	2016	Д.Дашмөнх	Эдогава Рампо	Хүн сандал	тууж	Хүн сандаг

概要

近年日本とモンゴル両国の親善協力関係が促進されるにつれ、日モ語とモ日語の翻訳と日本語教育の研究が活発に行われている。日モ語の翻訳はXX世紀後半から本格的に行われており、1953-2015年の間合計500件以上の翻訳が登録されている。しかし、日モ語の翻訳研究はほとんど行われていなく、特に翻訳批評研究が行われていないといっても過言ではない。よって、モンゴルにおける日本語教育研究の展開が活発に行われているこの時代に翻訳研究の普及と振興が教授法や研究方法問題に新たな観点と解明を運ぶ点で重要な意義と役割をもつと考える。